

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

---

---

**5.2. Хэрэглэгчийн үнэлгээ:**

Төр засаг болон орон нутгийн төр, захиргааны байгууллагуудын гаргасан шийдвэр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа болон төрийн байгууллагуудын ажил үйлчилгээний талаар иргэдийн саналыг судлах ажлыг 2 удаа зохион байгуулсан юм.

**5.2.1. Сумдын ЗДТГ зохион байгуулж авч явуулсан судалгаа:**

2009 оны 12, 2010 оны 1 дүгээр саруудад сумдын Засаг даргын Тамгын газруудад үүрэг чиглэл өгч иргэдээс санал авах ажлыг зохион байгууллаа. /Аравдугаар хавсралт/

2009 оны жилийн эцэст аймгийн хэмжээнд 57733 хүн оршин сууж байгаагийн 2,40 хувь буюу 1387 хүнээс уг санал асуулгыг авчээ. Судалгаа нийтдээ 40 асуулттай бөгөөд аймгийн хэмжээнд 55480 хариулт өгөгдсөн байна. /Хавсралт №10а/

Нийт асуултын 19,5 хувьд „мэдэхгүй,, гэсэн хариулт өгсөн нь төр засгийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажил хүн бүрт хүртээмжтэй биш, мэдээлэл хомс байгаатай холбоотой гэж үзэж байна. Мөн 19,2 хувь нь „хангалтгүй,, гэсэн хариулт өгсөн байна. Үндсэндээ 38,7 хувь нь сөрөг /муу/, 24,9 хувь нь дундаж түвшний, 36,2 хувь нь эерэг /сайн/ үнэлгээ өгсөн байна.

Иргэдийн ихэнх нь ядуу амьдарч, зуд турхан нүүрлэж, төр засгийн бодлого тууштай биш байгаад бухимдаж байна. Ялангуяа ядуу иргэдийн амьжиргааг тэтгэж байсан хүүхэд, шинээр гэр бүл бологсад, шинэ төрсөн хүүхдэд олгож байсан мөнгийг өгөхгүй болсон, хэдийгээр өөр хэлбэрээр, өөр сангаас хувь хишиг хүртээх болсон ч судалгаа авч байх үед тэр нь удаашралтай, чирэгдэлтэй байсан, сонгуулийн үеийн амлалтуудыг өгч чадахгүй болж уучлал гуйхад хүрээд байгаа зэрэг нь хүмүүст тааламжгүй сэтгэл төрүүлж, энэ санаагаа санал асуулгын хуудсаар илэрхийлсэн байна.

Хууль тогтоомжийн талаархи мэдээлэл, сурталчилгаа, хэрэгжилт ямар түвшинд байгааг харуулах нэгдүгээр бүлэг асуултанд „бүрэн хангалттай,, „хангалттай,, гэсэн хариултыг 30,3 хувь нь өгсөн байхад „хангалтгүй,, „мэдэхгүй,, гэсэн хариулт 43,9 хувийг эзэлж байна.

Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрөө ямар түвшинд хэрэгжүүлж байгаа, төрийн захиргааны төв байгууллагуудын ажил, үйлчилгээ ямар түвшинд байгааг харуулах хоёрдугаар бүлэг асуултанд „бүрэн хангалттай,, „хангалттай,, гэсэн хариулт 33,2 хувь, „хангалтгүй,, „мэдэхгүй,, гэсэн хариулт 39,9 хувийг эзэлж байна.

Аймгийн ИТХ, Засаг дарга, аймгийн төр, захиргааны байгууллагуудын ажил үйлчилгээний үр дүнг харуулах гуравдугаар бүлэг асуултанд „бүрэн хангалттай,, „хангалттай,, гэсэн хариулт 31,6 хувь, „хангалтгүй,, „мэдэхгүй,, гэсэн хариулт 42,7 хувийг эзэлж байна.

Харин сумын ИТХ, Засаг дарга, сумын төр, захиргааны байгууллагуудын ажил үйлчилгээний үр дүнг харуулах дөрөвдүгээр бүлэг асуултын хариулт бусдаас арай дээр байна. „Бүрэн хангалттай,, „хангалттай,, гэсэн хариулт 46,6 хувь, „хангалтгүй,, „мэдэхгүй,, гэсэн хариулт 30,7 хувийг эзэлж байна.

Иргэд, олон түмний дунд байж, хүсэн хүлээсэн асуудлыг нь шийдвэрлэж байгаа сумын удирдлагуудад иргэд талархалтай ханддаг бөгөөд энэ чанараараа үнэлгээ нь муугүй байдаг. Дэлгэрэх, Даланжаргалан, Иххэт, Улаанбадрах, Хөвсгөл сумдад санал асуулганд оролцогчдын 60,0-аас дээш хувь нь эерэг үнэлгээ өгсөн бол Хатанбулаг суманд дөнгөж 26,8 хувь нь сайнаар үнэлсэн байна.

Харин судалгааг хэн, хэзээ, ямар хүрээнд, зорилгоо хэрхэн ойлгуулж авснаас үр дүн өөр болдгийг бодолцох учиртай. Сумдаас ирүүлэх судалгаатай харьцуулж үзэх зорилгоор аймгийн ЗДТГ-ын ажлын хэсгүүд 2009 оны 10 дугаар сард бүх сумдад ажиллаж, сум бүрт 20-оос доошгүй хүнээс судалгаа авсан юм.

#### **5.2.2. Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж авч явуулсан судалгаа:**

Судалгаанд нийгмийн янз бүрийн төлөөлөл оруулах, хөндлөнгийн нөлөөгүйгээр хариулах боломжийг олгох талаар дээрхи журамд заасныг хэрэгжүүлэх, ажлын хэсгийн гишүүд аль болохоор өөрсдөө уг судалгааг авах зорилго тавьсан болно.

Аймгийн хэмжээгээр 284 иргэнийг уг судалгаанд хамруулсны дотор малчин 48 /судалгаанд оролцогчдын 16,9 хувь/, аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшилд ажиллагсад 71 /25,0 хувь/, төрийн албан хаагч 64 /22,5 хувь/, ажилгүй иргэд 61 /21,4 хувь/, өндөр настан 40 /14,0 хувь/ тус тус эзэлж байна. /Хавсралт №10б/

Оролцогч бүр 40 асуулттай судалгааны хүснэгт бөглөж, аймгийн дүнгээр 11360 асуултанд хариулсан ба тэдний 34,4 хувь нь төр засгийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого шийдвэрийн хэрэгжилт, ажил үйлчилгээний чанарт бүрэн хангалттай, хангалттай гэсэн хариулт, харин 39,9 хувь нь хангалтгүй буюу мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. /Хавсралт №10в/

Иргэд сумынхаа Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааны талаар арай илүү мэдээлэлтэй байж, нийт хариултын 46,0 хувь нь эерэг, өөдрөг байдлаар өгөгдсөн байхад хууль тогтоомжийн сурталчилгаа, түүний хэрэгжилт, Засгийн газрын бодлого, шийдвэрийн хэрэгжилтэнд 41,9-46,3 хувь нь өөдрөг бус /хангалтгүй, мэдэхгүй гэсэн/ хариулт өгчээ.

Алтанширээ, Дэлгэрэх, Замын-Үүд сумд аймгийн Засаг даргын бодлого, үйл ажиллагааны мэдээлэл арай сайн хүрч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Сумдын Засаг дарга нарын үйл ажиллагааны үр дүнд иргэд дундаж түвшний үнэлгээ өгсөн байна. Хамгийн сайн үнэлгээ өгсөн сумд Алтанширээ, Иххэт, Замын-Үүд, Улаанбадрах, харин муу үнэлгээ өгсөн сумд Мандах, Айраг, Сайхандулаан, Эрдэнэ сумд байна. Нийгэмд хэрэгтэй чухал асуудлыг шийдвэрлэсэн нь иргэдийн санаа сэтгэлд нөлөөлж, үнэлгээг дээшлүүлдэг нь Алтанширээ, Иххэт сумын жишээн дээр харагдсан болно. Алтанширээ суманд ундны усыг цэнгэгшүүлэх төхөөрөмж тавьж, энгийн амталгаагаар мэдэгдэх хэмжээнд хүргэж сайжруулсан, Иххэт суманд дулааны зуухны засварыг сайн хийж, дулаан хангамжийг өмнөх жилүүдийнхээс эрс сайжруулсан зэргийг уулзсан хүн бүр магтаж сайшааж байлаа.

Хэрэглэгчийн үнэлгээний хувийг тавихдаа дээрхи 2 судалгааны ерөнхий дүнгийн дунджийг авав. Тухайлбал, Сумдын ЗДТГ-аас авсан судалгаанд иргэдийн 80,7 хувь нь „хангалтгүй,,-гээс бусад үнэлгээг, аймгийн ЗДТГ-аас авсан судалгаанд 80,0 хувь нь мөн үнэлгээг өгсөн бөгөөд дундаж нь 80,35 байна.

**ТӨР ЗАСГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨР, ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫН БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ,  
ТӨРИЙН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР ИРГЭДЭЭС  
АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН**

2009 оны 12, 2010 оны 1 дүгээр сар

№	Асуулгын агуулга, сумын нэр	Санал асуулганд оролцогчдоос өгсөн саналын тоо	Бүрэн хангалттай	Хангалттай	Төдийлөн хангалттай биш	Хангалтгүй	Мэдэхгүй буюу хариулаагүй	Тайлбар
<b>Нэг. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх таны бодол, дүгнэлт</b>								
1	Айраг	120	4	22	37	30	27	
2	Алтанширээ	270	5	106	66	62	31	
3	Даланжаргалан	264	58	54	61	47	44	
4	Дэлгэрэх	540	51	167	96	77	149	
5	Замын-Үүд	2772	240	586	716	631	599	
6	Иххэт	240	15	64	50	41	70	
7	Мандах	120	11	35	13	9	52	
8	Өргөн	120	8	25	37	27	23	
9	Сайншанд	2310	173	427	632	570	508	
10	Сайхандулаан	162	5	24	50	52	31	
11	Улаанбадрах	480	79	96	115	111	79	
12	Хатанбулаг	462	47	78	142	115	80	
13	Хөвсгөл	96	2	38	23	28	5	
14	Эрдэнэ	420	54	65	114	97	90	
	ДҮН	8376	752	1787	2152	1897	1788	
<b>Хоёр: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх бодол, дүгнэлт</b>								
1	Айраг	180	2	56	45	41	36	
2	Алтанширээ	405	16	128	99	85	77	
3	Даланжаргалан	396	97	94	102	46	57	
4	Дэлгэрэх	810	242	295	129	48	96	
5	Замын-Үүд	4158	290	762	1104	1034	968	
6	Иххэт	360	27	133	62	32	106	
7	Мандах	180	9	87	9	9	66	
8	Өргөн	180	12	46	55	41	26	
9	Сайншанд	3465	259	735	1008	752	711	
10	Сайхандулаан	243	6	68	106	29	34	
11	Улаанбадрах	720	205	176	144	110	85	

12	Хатанбулаг	693	37	121	283	133	119	
13	Хөвсгөл	144	-	61	45	18	20	
14	Эрдэнэ	630	102	112	180	95	141	
	ДҮН	12564	1304	2874	3371	2473	2542	
<b>Гурав: Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх таны бодол, дүгнэлт</b>								
1	Айраг	260	5	62	60	51	82	
2	Алтанширээ	585	3	145	157	166	114	
3	Даланжаргалан	572	126	164	119	52	111	
4	Дэлгэрэх	1170	404	341	153	135	137	
5	Замын-Үүд	6006	302	913	1517	1478	1796	
6	Иххэт	520	39	167	194	35	85	
7	Мандах	260	15	132	96	5	12	
8	Өргөн	260	15	52	60	61	72	
9	Сайншанд	5005	409	1251	1279	1002	1064	
10	Сайхандулаан	351	23	111	94	44	79	
11	Улаанбадрах	1040	266	224	239	191	120	
12	Хатанбулаг	1001	54	165	396	152	234	
13	Хөвсгөл	208	-	55	65	50	38	
14	Эрдэнэ	910	147	162	207	174	220	
	ДҮН	18148	1808	3944	4636	3596	4164	
<b>Дөрөв: Сумын ажил, үйлчилгээний талаар таны бодол, дүгнэлт</b>								
1	Айраг	240	23	109	54	31	23	
2	Алтанширээ	540	27	189	131	93	100	
3	Даланжаргалан	528	199	148	82	38	61	
4	Дэлгэрэх	1080	404	341	136	127	72	
5	Замын-Үүд	5544	1071	1284	1264	841	1084	
6	Иххэт	480	95	205	80	15	85	
7	Мандах	240	22	108	77	32	1	
8	Өргөн	240	28	105	44	41	22	
9	Сайншанд	4260	488	1311	1090	881	490	
10	Сайхандулаан	324	52	114	82	50	26	
11	Улаанбадрах	960	356	236	163	142	63	
12	Хатанбулаг	924	60	188	285	238	153	
13	Хөвсгөл	192	2	132	38	12	8	
14	Эрдэнэ	840	200	151	184	146	159	
	ДҮН	16392	3027	4621	3710	2687	2347	
<b>ЕРӨНХИЙ ДҮН</b>		<b>55480</b>	<b>6891</b>	<b>13226</b>	<b>13869</b>	<b>10653</b>	<b>10841</b>	

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ**

**ТӨР ЗАСГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨР, ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫН БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ,  
ТӨРИЙН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР ИРГЭДЭЭС  
АВСАН САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС**

Сумын нэр .....

..... оны..... дугаар сарын .... ны өдөр

№	Асуулгын агуулга	Бүрэн хангалттай	Хангалттай	Төдийлөн хангалттай биш	Хангалтгүй	Мэдэхгүй
<b>Нэг. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаар таны бодол, дүгнэлт</b>						
1	Хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, сурталчилгаа хангалттай хийгдэж байна уу?					
2	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрүүд орон нутагт аль хир хэрэгжиж байна вэ?					
3	Иргэд Засгийн газрын бодлого, шийдвэрт өөрийн дуу хоолой, санал бодлоо илэрхийлэх боломжоор хангагдсан гэж үздэг үү?					
4	Хуулийн байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хангалттай ажиллаж байна уу?					
5	Хуулийн байгууллагууд хэр зэрэг шударга ажиллаж, үнэн, бодитой шийдвэр гаргадаг вэ?					
6	Төрийн албан хаагчид авилга авах явдлаас ангид байж чаддаг уу?					
<b>Хоёр: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар таны бодол, дүгнэлт</b>						
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар та хангалттай сайн мэддэг үү?					
2	Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрөө ямар түвшинд хэрэгжүүлж байна вэ?					
3	Төрийн захиргааны байгууллагуудын ажил, үйлчилгээ ямар түвшинд явагдаж байна вэ?					
4	Боловсролын талаар гаргасан Засгийн газрын шийдвэрүүд аль хир хэрэгжиж байна вэ?					
5	Эрүүл мэндийн талаар гаргасан Засгийн газрын шийдвэрүүд					

	аль хир хэрэгжиж байна вэ?					
6	Биеийн тамир, спортын талаар гаргасан Засгийн газрын шийдвэрүүд аль хир хэрэгжиж байна вэ?					
7	Соёлын үйлчилгээний талаар гаргасан Засгийн газрын шийдвэрүүд аль хир хэрэгжиж байна вэ?					
8	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын хэрэгжилтэнд та ямар үнэлгээ өгөх вэ?					
9	Ядуурал, ажилгүйдлийг бууруулах талаар зохиож байгаа ажилд та ямар үнэлгээ өгөх вэ?					
<b>Гурав: Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар таны бодол, дүгнэлт</b>						
1	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар та хангалттай сайн мэддэг үү?					
2	Аймгийн Засаг дарга үйл ажиллагааны хөтөлбөрөө ямар түвшинд хэрэгжүүлж байна вэ?					
3	Аймгийн Засаг даргын шийдвэрт иргэд, олон нийтийн санал тусгагддаг уу?					
4	Аймгийн хэмжээнд төрийн захиргааны байгууллагуудын ажил, үйлчилгээ ямар түвшинд явагдаж байна вэ?					
5	Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн үйлчилгээ ямар түвшинд явагдаж байна вэ?					
6	Аймгийн хэмжээнд нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ ямар түвшинд явагдаж байна вэ?					
7	Аймгийн хэмжээнд боловсролын үйлчилгээ ямар түвшинд явагдаж байна вэ?					
8	Аймгийн хэмжээнд соёлын үйлчилгээ ямар түвшинд явагдаж байна вэ?					
9	Аймгийн Засаг дарга иргэд хөдөлмөрчидтэйгээ байнга уулзаж, санал бодлыг нь сонсдог уу?					
10	Байгууллага, иргэдээс гарсан санал, санаачлагыг аймгийн Засаг дарга аль хир дэмжиж, тусалдаг вэ?					
11	Ажлын байрны тоог нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр хангалттай ажиллаж байна уу?					
12	Аймгийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрлэл хэр зэрэг хөгжиж байна вэ?					
13	Аймагт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажил хир зэрэг хийгдэж байна вэ?					
<b>Дөрөв: Сумын ажил, үйлчилгээний талаар таны бодол, дүгнэлт</b>						
1	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар та хангалттай сайн мэддэг үү?					
2	Сумын Засаг дарга үйл ажиллагааны хөтөлбөрөө ямар түвшинд хэрэгжүүлж байна вэ?					
3	Суманд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажил хир зэрэг хийгдэж байна вэ?					
4	Сумын ЗДТГ-ын ажил, үйлчилгээний үр дүнг та хэрхэн үнэлж байна вэ?					
5	Сумын хүн эмнэлгийн үйлчилгээ ямар түвшинд явагдаж байна вэ?					
6	Сумын хэмжээнд соёлын үйлчилгээ ямар түвшинд явагдаж байна вэ?					
7	Ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний талаар таны үнэлгээ?					
8	Хүүхдийн цэцэрлэгийн үйлчилгээний талаар таны үнэлгээ?					
9	Дулаан хангамжийн үйлчилгээний чанарт та ямар үнэлгээ өгөх вэ?					

10	Хүн амын ундны цэвэр усны хангамжийн талаар та ямар үнэлгээ өгөх вэ?					
11	Цахилгаан эрчим хүчний хангамжийн талаар та ямар үнэлгээ өгөх вэ?					
12	Газар эзэмшүүлэх, өмчлүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд, хөнгөн шуурхай зохион байгуулж чадаж байна уу?					

Танд баярлалаа.

### ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

#### ТӨР, ЗАСГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ТӨРИЙН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР АВСАН САНАЛ АСУУЛГАНД ОРОЛЦСОН ХҮМҮҮСИЙН ТОО, НИЙГМИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

2009 оны 11 дүгээр сарын 10

Сумын нэр	Санал асуулганд оролцсон нийт хүний тоо	Санал асуулганд оролцогчдын нийгмийн байдал				
		Малчин	Хувийн хэвшилд ажиллагч	Төрийн албан хаагч	Ажилгүй иргэд	Өндөр настнууд
Айраг	20	3	4	6	4	3
Алтанширээ	20	4	5	4	4	3
Даланжаргалан	20	2	4	7	5	2
Дэлгэрэх	20	4	3	3	5	5
Замын-Үүд	20	-	11	6	1	2
Иххэт	20	4	3	5	5	3
Мандах	20	2	8	2	6	2
Өргөн	20	2	4	9	4	1
Сайхандулаан	23	7	4	4	4	4
Сайншанд	20	3	5	3	5	4
Улаанбадрах	20	2	4	5	6	3
Хатанбулаг	19	4	5	3	4	3
Хөвсгөл	22	5	6	3	5	3
Эрдэнэ	20	6	5	4	3	2
<b>БҮГД</b>	<b>284</b>	<b>48</b>	<b>71</b>	<b>64</b>	<b>61</b>	<b>40</b>

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТЗУХ-ИЙН  
**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ**

**ТӨР, ЗАСГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ТӨРИЙН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТАЛААР ИРГЭДЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН**

2009 оны 11 дүгээр сарын 10

№	Сумын нэр	1. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн сурталчилгаа, хэрэгжилтэнд өгсөн үнэлгээ								2. Засгийн газрын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ								3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ							
		Санал асуулгын асуултын тоо	Бүрэн Хангалттай	Төдийлөн хангалттай биш Хангалтгүй	Мэдэхгүй	үнэлгээ		Санал асуулгын асуултын тоо	Бүрэн Хангалттай	Төдийлөн хангалттай биш Хангалтгүй	Мэдэхгүй	үнэлгээ		Санал асуулгын асуултын тоо	Бүрэн хангалттай	Хангалттай	Төдийлөн хангалттай биш Хангалтгүй	Мэдэхгүй	үнэлгээ						
						3+4-ийн хувь	6+7-ийн хувь					11+12-ийн хувь	14+15-ийн хувь						19+20-ийн хувь	22+23-ийн хувь					
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25
1	Айраг	120	5	18	27	49	21	19,1	58,3	180	6	27	40	70	37	18,3	59,4	260	9	41	54	77	79	19,2	60,0
2	А/ширээ	120	4	47	28	11	30	42,5	34,1	180	3	120	24	25	26	58,3	28,3	260	3	139	32	20	66	54,8	33,0
3	Далан	120	1	22	37	37	23	19,6	50,0	180	2	31	76	32	39	18,3	39,4	260	1	43	95	36	85	16,9	46,5
4	Дэлгэрэх	120	7	34	29	18	32	34,1	41,6	180	5	47	42	37	49	28,8	47,7	260	14	94	40	34	78	41,5	43,3
5	З/үүд	120	5	38	29	28	20	35,8	40,0	180	5	64	42	45	24	38,3	38,3	260	4	102	65	45	44	40,7	34,2
6	Иххэт	120	13	32	25	31	19	37,5	41,6	180	8	62	45	27	38	38,8	36,1	260	14	69	45	29	103	31,9	50,7
7	Мандах	120	6	27	40	25	22	27,5	39,1	180	3	38	71	27	41	22,7	37,7	260	11	67	90	43	49	30,0	35,3
8	Өргөн	120	1	29	41	29	20	23,0	40,8	180	1	65	67	25	22	36,6	26,1	260	19	70	74	70	27	34,2	37,3
9	Сайншанд	120	5	37	34	30	14	35,0	36,6	180	70	67	46	31	29	41,1	33,3	260	16	59	63	58	64	24,6	46,9
10	С/дулаан	138	4	29	35	36	34	23,9	50,1	207	1	55	62	36	53	27,0	42,9	299	5	69	85	40	100	24,7	46,8
11	У/бадрах	120	2	28	37	28	25	25,0	44,1	180	2	52	40	40	46	30,0	47,7	260	6	59	66	33	96	25,0	49,6
12	Хатан	114	2	13	37	32	30	13,1	54,3	171	3	26	53	39	50	16,9	52,0	247	9	62	63	40	73	27,7	45,7
13	Хөвсгөл	132	4	18	34	55	21	16,6	57,5	198	2	39	69	55	33	20,7	44,4	286	7	75	89	59	56	28,6	40,2
14	Эрдэнэ	120	3	20	27	47	23	19,1	58,3	180	4	32	47	48	49	20,0	53,8	260	3	57	53	63	84	23,0	56,5
	<b>ДҮН</b>	<b>1704</b>	<b>62</b>	<b>392</b>	<b>460</b>	<b>456</b>	<b>334</b>	<b>26,6</b>	<b>46,3</b>	<b>2556</b>	<b>52</b>	<b>707</b>	<b>724</b>	<b>537</b>	<b>536</b>	<b>29,6</b>	<b>41,9</b>	<b>3692</b>	<b>121</b>	<b>1006</b>	<b>914</b>	<b>647</b>	<b>1004</b>	<b>30,5</b>	<b>44,7</b>

Үргэлжлэл-2

№	Сумын нэр	4. Сумын Засаг даргын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ								5. Сумын дүн							
		Санал асуулгын асуулгын тоо	Бүрэн хангалттай	Хангалттай	Төдийлөн хангалттай биш	Хангалтгүй	Мэдэхгүй	үнэлгээ		Санал асуулгын асуулгын тоо	Бүрэн хангалттай	Хангалттай	Төдийлөн хангалттай биш	Хангалтгүй	Мэдэхгүй	үнэлгээ	
								3+4-ийн хувь	6+7-ийн хувь							3+4-ийн хувь	6+7-ийн хувь
A	1	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41
1	Айраг	240	18	68	54	69	31	35,8	41,6	800	38	154	175	265	168	24,0	54,1
2	Алтанширээ	240	21	179	24	7	9	83,3	6,6	800	31	467	108	63	131	62,2	24,2
3	Даланжаргалан	240	17	72	77	48	26	37,0	30,8	800	21	168	285	153	173	23,6	40,7
4	Дэлгэрэх	240	19	107	54	46	14	52,5	25,0	800	45	282	165	135	173	40,8	38,5
5	Замын-Үүд	240	80	72	75	62	23	52,5	35,5	800	22	276	211	180	111	37,2	36,3
6	Иххэт	240	46	112	31	31	20	65,8	21,2	800	81	275	146	118	180	44,5	37,2
7	Мандах	240	5	52	70	68	45	23,7	47,0	800	25	184	271	163	157	26,1	40,0
8	Өргөн	240	11	116	65	18	30	52,9	20,0	800	32	280	247	142	99	39,0	30,1
9	Сайншанд	240	22	78	53	41	46	41,6	36,2	800	50	241	196	160	153	36,3	39,1
10	Сайхандулаан	276	18	94	62	52	50	40,5	36,9	920	28	247	244	164	237	29,8	43,5
11	Улаанбадрах	240	19	111	58	33	19	54,1	21,6	800	29	250	201	134	186	34,8	40,0
12	Хатанбулаг	228	9	76	65	51	27	37,2	34,2	760	23	177	218	162	180	29,8	45,0
13	Хөвсгөл	264	22	108	66	42	26	49,2	25,7	880	35	240	258	211	136	31,2	39,4
14	Эрдэнэ	240	9	81	62	62	26	37,5	36,6	800	19	190	189	220	182	26,1	50,2
<b>ДҮН</b>		<b>3408</b>	<b>244</b>	<b>1326</b>	<b>816</b>	<b>630</b>	<b>392</b>	<b>46,0</b>	<b>29,9</b>	<b>11360</b>	<b>479</b>	<b>3431</b>	<b>2914</b>	<b>2270</b>	<b>2266</b>	<b>34,4</b>	<b>39,9</b>

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ**

